



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/1163

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд худалдан авах Сонгинохайрхан дүүргийн тохижилт, сэргээн босголтын шуурхай албаны машин, механизмын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд шилжүүлэн, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

3.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын 58.1.16-гийн "12"-т тусгагдсан Дүүргүүдийн тохижилт, сэргээн босголтын шуурхай албаны машин, механизмын зардлаас гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, захиалагчийн хяналт тавьж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ,
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ  Ж.БАТБАЯСГАЛАН




111020000732

Нийслэлийн Засаг даргын 2019 оны

...сарын ...-ны өдрийн

...захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ, СЭРГЭЭН
БОСГОЛТЫН ШУУРХАЙ АЛБАНЫ МАШИН,
МЕХАНИЗМЫН ЖАГСААЛТ

/төгрөг/

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Төсөвт өртөг
1	Экскватор /1ш/	Шанаганы багтаамж 0.58м ³ ба түүнээс дээш	377,186,000
2	Авто грейдер /1ш/	15,400 кг	285,000,000
3	Асфальтны индүү /1ш/	8 тн	125,000,000
4	Крантай авто машин /1ш/	3.5 тн / краны даац 1.5 тн	80,000,000
5	Авто ачигч /1ш/	-	80,000,000
6	Асфальтны хөрөө /1ш/	усан хөргүүртэй 13 морины хүчтэй	5,600,000
7	Хийн компрессор /1ш/	8 бар	45,000,000
8	Хийн компрессорын хошуу /үлээх/		25,000
	ДҮН		997,811,000